

Хүнс, хөдөө аж ахуйн газарт холбогдолтой Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт						
2024 оны жилийн эцэс						
Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ
МУ-ын хууль						
4	11	Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ 2021-05-06 Дугаар 2021.05.06	43.2.1. хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран Хоршоологчдыг чадавхжуулах сургалтыг 2024 оны 12-дугаар сарын 11 -нд зохион байгуулж, 15 сумын 90 гаруй хоршооны төлөөлөл болон хөдөө аж ахуйн тасгийн Жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтнүүдийг хамрууллаа.Зээл авсан хоршоодын гишүүдэд зориулан Хоршооны менежмент үйл ажиллагаа, санхүүгийн удирдлага, Мал үржүүлэг технологи, ХАА-н гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, бэлчээр ашиглалт, тэжээл тариалалт, мал бордох технологийн талаарх сургалтыг Хөдөө, аж ахуйн их сургуулийн багш нар удирдан явуулав. Дундговь аймгийн хэмжээнд 10 сарын 31-ний өдрийн байдлаар 401 хоршоо байгуулагдсан. Үүнээс Төрийн болон ХААН банкнаас 316 хоршооны 1081 гишүүн малчин өрх 35,1 тэрбум төгрөгийн хоршооны зээл авсан байна.	100	100
УИХ-ын байнгын хорооны тогтоол						

24	49	<p>Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ</p>	<p>1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;</p>	<p>Мах экспортолдог аж ахуй нэг байхгүй. Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч иргэн, ААНэгжүүд хувийн хөрөнгөөр 293 тн махыг нөөцөлж хавар, зуны улиралд аймгийн төвийн суурин хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн. 2025 оны Хүн амын хэрэгцээнд нийлүүлэх махны нөөцийг, махны худалдаа эрхлэгч иргэн ААНэгжүүд өөрсдийн хөрөнгөөр нөөцөлж эхлээд байна. Одоогоор нийт 210 тн мах байна. /хонь 130тн, ямаа 173тн, үхэр 7тн/</p>	100	90
----	----	--	---	--	-----	----

27	59	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-01-17 Дугаар 2022 №01 БОХХААБХ	<p>1.5/. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалах, таримлын зохистой сэлгээг сонгон нэвтрүүлж, малын тэжээл болон бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 15 хувиас хэтрүүлэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тонн ургац хураан авсан.</p>	100	100
----	----	--	--	--	-----	-----

	60		<p>1.9/. Хүнсний хангамж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор усны эх үүсвэр бүхий газарт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, малын тэжээл, ашигт таримал тариалах, мод үржүүлгийн газар байгуулахад шинээр газар олгох асуудлыг судалж шийдвэрлэх, нийслэл хот, говийн бүсийн болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудыг түшиглэн өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуй, хадгалалт борлуулалтын цогцолбор төв байгуулахад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, хүлэмжид хэрэглэсэн цахилгааны хөнгөлөлтийн цагийн хугацааг уртасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>	<p>Орон нутгийн үйлдвэрлэлээр хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 22% хангаж, аймгийн хэмжээнд 15 сумын 6 хоршоо, 13 ААН, 172 иргэн нийт 91,8 га-д тариалалт хийж төмс 24,8 га-аас 225,3 тн, хүнсний ногоо 25,7 га-аас 219 тн, жимс жимсгэнэ 4,6 га-аас 4,64 тн , малын тэжээл-34,8 га-аас 33,5 тн-ийг тус тус хураан авсан.Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжний зориулалтаар Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 179.5 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлд хамдагдаж 0,5 га талбайд 300м.кв хүлэмжинд хүнсний нарийн ногоо тариалж 3,2 тн өргөст хэмх, 1120м.кв хүлэмжид эрт ургацын байцаа, өргөст хэмх тариалж 16,5 тн ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлсэн. Сайнцагаан сумын иргэн хувийн хөрөнгө оруулалтаар 170,0 сая төгрөгөөр шинээр 3 га талбайг хашаажуулж, зуны 1400 м.кв талбай бүхий хүлэмжийг барьж тарвас, лооль, өргөст хэмх, эрдэнэшиш тариалж нийт 3,5 тн-ургац хураан авсан. Энэ онд орон нутгийн түвшинд шинээр 6,8 га-д тариалалт хийж , нийт 23,2 тн-ийг ургац хураан авч, орон нутгийн зах зээлд борлуулж аймгийн хэмжээнд нийт 85,58 га талбайд жимс жимсгэний тариалалт хийж, өмнөх оноос шинээр 4 га талбай нэмэгдсэн. 4 төрлийн сортын алимны суулгац тариалж ургалтын 90 хувьтай байна. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд “Их Хайрханы хаялага” компани гүйцэтгэгчээр шалгарч нийт 40 га талбайд агро ойжуулалтын ажлыг хийж аймгийн төвөөс 5 км зайд улсын чанартай авто зам дагуу 9-12 эгнээ хамгаалалтын зурваст улиас, хайлаас, шар хуайс, бургас мод 19000 ширхгийг, гол талбайд жимсний плантацид чацаргана, тэхийг шээг, голт бор, ерөл, гүйлс, монос, далан хальс зэрэг мод 8000 нийт 27000 ширхэг мод тарьсан.</p>	100	100
--	----	--	---	--	-----	-----

31	72	Чиглэл өгөх тухай 2022-06-15 Дугаар 2022 №07 ҮББХ	1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор малын тэжээл тариалах газрын асуудлыг шийдвэрлэх, зуны улиралд сүүний илүүдэлтэй аймгуудад сүү цуглуулах цэг болон боловсруулах үйлдвэрийг кластерын зарчмаар хөгжүүлэх, импортын хуурай сүүг орлох, хадгалалтын хугацаа урттай сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг байгуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх	Адаацаг сумын 2-р багийн малчин ДМөнхбаяр, М. Сумьяа Сүүний чиглэлийн Монбиллиард үүлдэрийн Сүүний чиглэлийн 4 үнээ худалдан авчирч орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлж байна. Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас сүүн, махны чиглэл Эрчимжсэн аж ахуй эрхлэх зориулалтаар Адаацаг сумын Адаацаг хонгор хайрхан ХХК, Сайнцагаан сумын Эргэх говь ХХК тус бүр 90.0 сая. төгрөг нийт 180.0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Нийт 2 бух 24 үнээг худалдан авсан. Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2 тонн ургац хураан авсан нь өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100	100
45	99	Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-02 Дугаар 2022_01	3.8. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн, кластераар хөгжүүлэх, хот суурин, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангаас сүүн, махны чиглэл Эрчимжсэн аж ахуй эрхлэх, зориулалтаар Адаацаг сумын Адаацаг хонгор хайрхан ХХК, Сайнцагаан сумын Эргэх говь ХХК тус бүр 90.0 сая. төгрөг нийт 180.0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. Нийт 2 бух 24 үнээг худалдан авсан. Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2 тонн ургац хураан аван Цаашид эрчимжсэн мал аж ахуй эрхлэх санаачилга нэмэгдэж байна. иргэдийн Адаацаг сумын 2-р багийн малчин Д.Мөнхбаяр, М. Сумьяа нар Сүүний чиглэлийн Монбиллиард үүлдэрийн Сүүний чиглэлийн 4 үнээ худалдан авчирч орон нутагт сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэлтийг нэмэгдүүлж байна.	100	100

ЗГ-ын тогтоол

72	137	<p align="center">Мах бэлтгэхэд зориулан олгох зээлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-12-20 Дугаар 2023_461</p>	<p>4. Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай</p>	<p>Мах бэлтгэн нийлүүлэлт, борлуулалт, чанар аюулгүй байдалд хяналт хийж 10053 мал эмнэлгийн гэрчилгээг малчид, иргэд, ААНэгжид олгосон. Үүнд: Амьтан (хэрэгцээлэх) 2236, Бүтээгдэхүүн 6693, Отор нүүдэл 230, Үржлийн зориулалтаар 889, Алдуул 5 мал эмнэлгийн гэрчилгээ олгосон. Хонины мах 2139.4 тн, Ямааны мах 819.7 тн, Адууны мах 629.8 тн, Тэмээний мах 431.5 тн, Үхрийн мах 348.6 тн нийт 4369 тн малын маханд чанар аюулгүй байдалд хяналт хийж мал эмнэлгийн гэрчилгээ олгосон.</p>	100	100
----	-----	--	---	---	-----	-----

85	155	<p>“Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024-04-24 Дугаар 2024_166</p>	<p>3.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сум, багийн Засаг дарга нарт даалгаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.</p>	<p>Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай, Сайнцагаан, Хулд суманд нийт 7 удаа болсон малчдын зөвлөгөөнд Шинэ хоршоо, ХХСан, ЖДҮХсангийн талаарх сургалт зохион байгуулсан хийсэн. Хамрагдсан иргэний тоо 260. Сумдын Хоршоо хариуцсан мэргэжилтэн нар шинээр хоршоо байгуулах хүсэлтэй малчин 2800 иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна. Үүний үр дүнд одоогын байдлаар Хулд суманд 37, Цагаандэлгэр суманд 17, Эрдэнэдалай суманд 34, Сайнцагаан суманд 98, Адаацаг суманд 49, Баянжаргалан суманд 11, Гурвансайхан суманд 24, Дэлгэрхангай суманд 6, Луус суманд 43, Өлзийт суманд 19, Дэлгэрцогт суманд 10, Дэрэн суманд 16, Өндөршил суманд 10, Сайхан-Овоо суманд 10, Говь-Угтаал суманд 17 нийт 401 хоршоо байгуулагдсан байна. Шинэ хоршоо хөдөлгөөнөөс Төрийн болон Хаан банкнаас 316 хоршооны 1081 гишүүн малчин 35,1 тэр.бум төгрөгийн зээл аваад байна.</p>	100	100
94	167	<p>Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2024-08-07 Дугаар 2024_28</p>	<p>3.1.. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай” Засгийн газрын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд</p>	<p>Энэ онд орон нутгийн түвшинд шинээр 6,8 га-д тариалалт хийж нийт 23,2 тн-ийг ургацыг хурааж авч, орон нутгийн зах зээлд борлуулсан байна. Засгийн газрын 2024 оны Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс-748,1тонн, тэжээл-303,6тонн буюу 76,5%-тай нөөц бүрдүүлэлтийг хангасан. Аймагийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тонн ургац</p>	100	100

		атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах;	хураан авсан. ХХААХҮС-ын 2016 оны А/71 тушаалын дагуу малчид өвс 2851.3тн, тэжээл 1774.5тн, гар тэжээл 1482.0тн, давс, хужир шүү 3380.2тн тэжээлийн нэгжид шилжүүлснээр 4464.3тн тэжээл бэлтгэж 83,8 хувьтай бэлтгэл хангагдсан.		
168	3.2. . Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;	Засгийн газрын 2024 оны Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс-748,1тонн, тэжээл-303,6тонн буюу 76,5%-тай нөөц бүрдүүлэлтийг хангасан.Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тонн ургац хураан авсан.Аймаг дундын отрын бүс нутаг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутагт Адаацаг, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын 8 өрхийн 9397 толгой мал, Говьсүмбэр аймгийн Малахын тал отрын бүс нутагт Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 8 малчин өрхийн 10472 толгой мал оторлуулахаар захиалга хүргүүлэн гэрээ байгуулан ажиллаж байна.Өөр аймгийн нутагт 53 өрхийн 33,8мянган толгой мал, аймаг дотроо 23 өрхийн 18,5 мянган толгой мал оторлож байна. Оторлож буй малчдын дийлэнх хувь нь тухайн бүс нутгуудад суурьшсан өрхүүд байна. ХХААГ-ын даргын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн зөвлөмжөөр сумдын Засаг дарга нар, холбогдох албан тушаалтнуудад отор нүүдлийн зохицуулалт хийх, отор нүүдлээр ирсэн болон гарсан малчин өрхүүдэд нийгэм, эрүүл мэндийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, шаардлагатай тохиолдолд оторлолтын гэрээ байгуулах хамтран ажиллах талаар чиглэл өгч ажилласан.	100	100	

169	3.3. Улсын тусгай хамгаалалттай болон хилийн зурвас газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагын зөвшөөрөл, гэрээний дагуу босоо чиглэлд отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах;	Аймаг дундын отрын бүс нутаг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутагт Адаацаг, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын 8 өрхийн 9397 толгой мал, Говьсүмбэр аймгийн Малахын тал отрын бүс нутагт Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 8 малчин өрхийн 10472 толгой мал оторлуулахаар захиалга хүргүүлэн гэрээ байгуулан ажиллаж байна.	100	100
170	3.4.. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах;	Сайнцагаан сумын Далай багийн Зээгийн амар булаг, Наран багийн Ширгүүн говийн амт хоршооноос ирсэн хүсэлтийн дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас зарласан төсөл сонгон шалгаруулалт явуулан тус хоршоодод 3,3 га газрыг олгосон байна.Шинээр Сайнцагаан суманд газар өмчлөх хүсэлтэй 3 хоршооны материал шинээр ирсэн байна. Энэ онд төсөл сонгон шалгаруулалт явагдаагүй байна.	100	100
171	4.Энэхүү тогтоолд заасан арга хэмжээг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумдын аюулгүй нөөц бүрдүүлэхэд Аймаг сумдын Мал хамгаалах сан, нөөц хөрөнгөнөөс 821,6 сая төгрөгийн санхүүжилтээр 740,1тн өвс, 303,6тн тэжээлийн нөөц бүрдүүлэн 281,9 сая төгрөгийн санхүүжилтээр дахин аюулгүй нөөцийн өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	100	100

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл

103	183	2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14	<p>ХИҮ.7.4. Мах, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтад байнгын хяналт тавьж, үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоох, зохиомлоор хомсдол бий болгох, борлуулалтын хэмжээг хязгаарлах зэрэг хууль тогтоомж зөрчих явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (Т.Гантулга), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;</p>	<p>Хяналт шалгалтад давхардсан тоогоор нийт 37 газрыг хамруулсан. Сайнцагаан сумын 30 аж ахуй нэгж, Баянжаргалан, Өндөршил сумдын хүнсний худалдаа эрхлэгч 7 дэлгүүрийн хүнсний ногоо, жимс, тахианы махны гарал үүсэл, шинжилгээний бичиг баримтад хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар гарал үүслийн бичиггүй бүтээгдэхүүн гараагүй бөгөөд барааны үнийн мэдээлэл тавиагүй 6 дутагдлыг арилгуулж ажиллаа.Худалдааны лангуу тавиурт хатаж чийгээ алдсан, 5 төрлийн 5,3 кг хүнсний ногоог газар дээр нь устгуулж, бараа бүтээгдэхүүний лангуу тавиур дутуу байсан 2 дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулж ажилласан.</p>	100	100
-----	-----	---	--	--	-----	-----

	207		<p>2.22. Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлдэг мал эмнэлгийн ажил, үйлчилгээний үнэ тарифыг шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;</p>	<p>Сангийн Сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ний өдрийн 118, А-201 дугаар хамтарсан тушаалын дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний хөлсний тарифыг бог-250, бод-450 төгрөг тооцож мөрдөн ажиллаж байна. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 34 дүгээр зүйлийн 34.5 -д “Орон - нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал батална” гэсэн заалтын дагуу мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тарифийг шинэчлэхээр ИТХ-д хуралд санал хүргүүлсэн. 12 сар ИТХ-д батлуулахаар ажиллалаа.</p>	90	
	216		<p>XVI.5.2. Нөөцийн махны бэлтгэх, зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, аймаг, нийслэлийн Засагдарга нарт даалгав</p>	<p>Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч иргэн, ААНэгжүүд хувийн хөрөнгөөр 293 тн махыг нөөцөлж хавар, зуны улиралд аймгийн төвийн суурин хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна.2025 оны хаврын улиралд орон нутгийн болон нийслэлийн хүн амын хэрэгцээнд нийлүүлэх махны нөөцийг, махны худалдаа эрхлэгч иргэн ААНэгжүүд өөрсдийн хөрөнгөөр нөөцөлж эхлээд байна. Одоогоор нийт 210 тн мах байна. /хонь 130тн, ямаа 173тн, үхэр 7тн/ Адууны мах-8000-10000 төгрөг, хонины мах-8000-9000төгрөг, үхрийн мах-12000-13500 төгрөгний ханштай орон нутгийн зах зээлд борлуулагдаж байна.</p>	100	100

	218		<p>XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав</p>	<p>Бэлчээрийн даацыг аймгийн нийт багийн нутгаар тооцоолж гаргасан дүнгээс үзвэл 38 % бэлчээрийн нөөцтэй, 38 % бэлчээр хүрэлцээтэй, 22 % даац 1-3 дахин хэтэрсэн, 2 % нь даац 3-5 дахин хэтэрсэн. Аймгийн дүнгээр нутгийн 76 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой. Харин нутгийн 22 хувьд нь 1-3 дахин хэтэрсэн, 2 хувьд нь 3-5 дахин хэтэрсэн. Аймаг дундын отрын бүс нутаг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутагт Адаацаг, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын 8 өрхийн 9397 толгой мал, Говьсүмбэр аймгийн Малахын тал отрын бүс нутагт Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 8 малчин өрхийн 10472 толгой мал оторлуулахаар захиалга хүргүүлэн гэрээ байгуулан ажиллаж байна. Өөр аймгийн нутагт 53 өрхийн 33,8 мянган толгой мал, аймаг дотроо 23 өрхийн 18,5 мянган толгой мал оторлож байна. Оторлож буй малчдын дийлэнх хувь нь тухайн бүс нутгуудад суурьшсан өрхүүд байна. ХХААГ-ын даргын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн зөвлөмжөөр сумдын Засаг дарга нар, холбогдох албан тушаалтнуудад отор нүүдлийн зохицуулалт хийх, отор нүүдлээр ирсэн болон гарсан малчин өрхүүдэд нийгэм, эрүүл мэндийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, шаардлагатай тохиолдолд оторлолтын гэрээ байгуулах хамтран ажиллах талаар чиглэл өгч ажилласан.</p>	100	100
	221		<p>XVII.2.4.. Орон нутагт мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкуудтай хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.</p>	<p>Сайнцагаан суманд үйл ажиллагаа явуулдаг махны худалдаа эрхлэгчид малчдын бэлтгэсэн махыг малчны хотноос буюу газар дээр нь очиж явуулын худалдан авалт хийж зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлж өөрийн болон Нийслэл, Өмнөговь аймгийн хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн байна. Мөн махны худалдаа эрхлэгч Баян Зэгстийн Говь ХХК нь малчдын хотноос 2000 бог малыг малчдын гар дээрээс авч Налайх дүүргийн Траст трейд махны үйлдвэрт худалдаалсан байна.</p>	100	100

126	222	<p>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52</p>	<p>XL.3.3. Батлагдсан төсөвт эх үүсвэрийнхээ хүрээнд мал, махны борлуулалт, худалдан авалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав</p>	<p>Батлагдсан төсөв байхгүй</p>	0	0
-----	-----	---	--	---------------------------------	---	---

138	238	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл2024-06-06Дугаар 2024_22	37.1.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий багийг орон нутагт үргэлжлүүлэн ажиллуулж, холбогдох албан хаагчдын албан томилолтын болон замын зардал, тээврийн хэрэгслийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга (захирал) нарт	Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай, Сайнцагаан, Хулд суманд нийт 7 удаа болсон малчдын зөвлөгөөнд Шинэ хоршоо, ХХСан, ЖДҮХсангийн талаарх сургалт зохион байгуулсан. Хамрагдсан иргэний тоо 260. Сумдын Хоршоо хариуцсан мэргэжилтэн нар шинээр хоршоо байгуулах хүсэлтэй малчин 2800 иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.Одоогийн байдлаар Хулд суманд 37, Цагаандэлгэр суманд 17, Эрдэнэдалай суманд 34, Сайнцагаан суманд 98, Адаацаг суманд 49, Баянжаргалан суманд 11, Гурвансайхан суманд 24, Дэлгэрхангай суманд 6, Луус суманд 43, Өлзийт суманд 19, Дэлгэрцогт суманд 10, Дэрэн суманд 16, Өндөршил суманд 10, Сайхан-Овоо суманд 10, Говь-Угтаал суманд 17 нийт 401 хоршоо байгуулагдсан байна. Шинэ хоршоо хөдөлгөөнөөс Төрийн болон Хаан банкнаас 316 хоршооны 1081 гишүүн малчин 35,1тэр.бум төгрөгийн зээл аваад байна.	100	100
-----	-----	--	---	---	-----	-----


143	244	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэл 2024-11-20 Дугаар 2024_40	40.19.5.3. “Өвлийн идэш” арга хэмжээнд малчдын хоршоодын оролцоог хангахад дэмжлэг үзүүлж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.” гэжээ.	<p>Нийслэлийн иргэдийг махаар хангах зорилгоор 2024 оны 12 сарын 12-ноос 12 сарын 21 хүртэлх хугацаанд “Хоршооноос-хотынхондоо” уриан доор “Өвлийн идэш-2024” арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уг арга хэмжээг Төв цэнгэлдэхэд зохион байгуулж Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Баянжаргалан, Сайнцагаан, Дэлгэрхангай, Сайхан-овоо зэрэг сумдын малчид, мал бүхий иргэд, хоршоологчид оролцсон. Сумдаас нийт 9 хоршооны 38 малчин, хоршоологч оролцож нийт 204 тн мах, 20,5 тн дайвар бүтээгдэхүүн, 7,5 тн цагаан идээ борлуулж нийт 2,4 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Уг арга хэмжээг аймаг, сумдын зарын групп дээр зар мэдээг тавьж сурталчлан худалдаанд оролцохоор ирсэн малчдын зогсоол дээр байрлуулах, борлуулалтын мэдээг холбогдох газруудад мэдээлэх, зураг авч баталгаажуулан зургийг илгээх зэргээр ажлыг зохион байгуулж ажилласан.</p> <p>Өвлийн идэш арга хэмжээний үед Дундговь аймгийн мах адууны мах 7000-8000₮, үхрийн мах 12000-14000₮, хонины мах 10000-12000₮, ямааны мах 7000₮ үнэ ханштай, эрэлт хэрэгцээ ихтэй, амт чанар сайтай, эрүүл, тарган махтай байгааг нийслэлийн иргэд мэддэг болсон байна.</p> <p>Айраг 9000-1000₮, аарц-9000-10000₮, бор ааруул 40,000₮, сүүн ааруул 45000₮, идээний тойруулган ааруул 450,000-500,000₮, эзгий-35,000₮, эмийн ургамлууд, цөцгийн тос, шар тос, цөгийн бал, самар, эрүүл мэндийн бүтээгдэхүүд зэрэг малчид хоршоологдын гараар бүтсэн малын гаралтай болон байгалийн цэвэр бүтээгдэхүүн борлуулагдсан чухал хэрэгцээтэй арга хэмжээ болж өнгөрсөн.</p>	100	100
-----	-----	--	---	--	-----	-----

144	246	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл 2024-11-27 Дугаар 2024_41	41.23.9.1. Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолын хавсралтаар баталсан аймаг, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс, тэжээлийн нөхөн бүрдүүлэлтийг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллахыг Баян-Өлгий, Дундговь, Завхан, Төв, Хэнтий аймгийн Засаг дарга нарт	Засгийн газрын 2024 оны Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс-748,1тонн, тэжээл-303,6тонн буюу 76,5%-тай нөөц бүрдүүлэлтийг хангасан. Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тонн ургац хураан авсан. ХХААХҮС-ын 2016 оны А/71 тушаалын дагуу малчид өвс 2851.3тн, тэжээл 1774.5тн, гар тэжээл 1482.0тн, давс, хужир шүү 3380.2тн тэжээлийн нэгжид шилжүүлснээр 4464.3тн тэжээл бэлтгэж 83,8 хувьтай бэлтгэл хангагдсан. цаашид нэмэлтээр өвс тэжээл хужир татан авч нөөцлөх ажил үргэлжилж байна.	100	100
			Үнэлгээний дундаж хувь	95.2	94.5	


ХЯНАСАН:
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА (албан тушаал) Б.МӨНХЖАРГАЛ
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА (албан тушаал) (гарын үсэг) Ж.ШИНЭ-УЯНГА
(гарын үсгийн тайлал)

144	246	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 41 дүгээр тэмдэглэл 2024-11-27 Дугаар 2024_41	41.23.9.1. Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолын хавсралтаар баталсан аймаг, сумын аюулгүйн нөөцөд бэлтгэх өвс, тэжээлийн нөхөн бүрдүүлэлтийг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллахыг Баян-Өлгий, Дундговь, Завхан, Төв, Хэнтий аймгийн Засаг дарга нарт	Засгийн газрын 2024 оны Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах 28 дугаар тогтоолын хүрээнд аймаг, сумдын Засаг даргын аюулгүй нөөцөд өвс-748,1тонн, тэжээл-303,6тонн буюу 76,5%-тай нөөц бүрдүүлэлтийг хангасан. Аймгийн хэмжээнд Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 80 малчин, 54,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 62,2тонн ургац хураан авсан. ХХААХҮС-ын 2016 оны А/71 тушаалын дагуу малчид өвс 2851.3тн, тэжээл 1774.5тн, гар тэжээл 1482.0тн, давс, хужир шүү 3380.2тн тэжээлийн нэгжид шилжүүлснээр 4464.3тн тэжээл бэлтгэж 83,8 хувьтай бэлтгэл хангагдсан. цаашид нэмэлтээр өвс тэжээл хужир татан авч нөөцлөх ажил үргэлжилж байна.	100	100
Үнэлгээний дундаж хувь				95.2	94.5	

ХЯНАСАН:
 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ
 (албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)
 ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА
 (албан тушаал) (гарын үсэг)

 Ж.ШИН'Э-УЯНГА
 (гарын үсгийн тайлал)